

ХАРЬЦАЛ БҮТЭЭВЭР БА ҮҮСГЭВЭР БҮТЭЭВЭР

Д.Цэрэнпил¹

Монгол хэлэнд тодорхой хэлзүйн утга илэрхийлдэг мөртлөө бүтэц өгүүлбэрт үгсийн хоорондын харьцаа заадаггүй, харин үндэс үүсгэх мөн чанар бүхий тодорхой бүлэг бүтээвэрүүдийг харьцал бүтээвэрийн бүрэлдэхүүнд оруулах эсэх тухай асуудалыг монгол хэл шинжлэлийн бүтээлүүдэд авч үзэхдээ нэр үгийн олон тоо, үйл үгийн хэв, байдалын, мөн үйлт нэрийн залгаваруудыг залгавар бүтээвэрийн ерөнхий ангилалын хүрээнд дагавар, нөхцөл хоёрын алинд нь оруулах тухай яригддаг. Ц.Өнөрбаян “Орчин цагийн монгол хэлний үгзүй” [1994] бүтээлдээ монгол хэлний залгавар бүтээвэрийн ерөнхий ангилалын талаар дотоод, гадаадын эрдэмтэдийн судалгааг тоймлон дурдаад (х.80-83) “Дээр дурдсанаас үзвэл монгол хэл судлаачид залгавар бүтээвэрийг дагавар буюу үг бүтээх дагавар, нөхцөл буюу үг хувилгах дагавар гэж хоёр ангилсаны хувьд зөрөөгүй боловч энэ хоёртоо чухам ямар ямар залгаварыг оруулах вэ? гэдэг дээр зөрөөтэй байгаа нь харагдаж байна. Гол маргаан нь үйл үгийн хэв, байдал, үйлт нэр, нэр үгийн олон тооны залгаварууд дээр байна” (х.83) гээд энэ нь чухам юунаас шалтгаалж байна вэ? гэдэг талаар өөрийн санал дүгнэлтийг бичжээ. Үүнд:

1. Тухайн бүтээвэрийн утга, үүрэг, байрын хоёрдмол шинжээс шалтгаалж байна.
2. Судлаачид дээр дурдсан хоёрдмол үүрэгтэй залгаваруудын аль нэг шинжийг нь өрөөсгөл барьж тодорхойлсоноос болж нэг бол дагаварт, эсвэл нөхцөлд оруулдаг байна (х.84) гэжээ.

Мөн энэ асуудалыг судлаач П.Бямбасан “Монгол хэлний залгавар морфемийн ангилалын асуудалд” [1977] өгүүлэлдээ хөндөж байв. Тэрбээр энэ санал зөрөлдөөний мөн чанарыг тоймлон дурдаад (х.168-170) “Монгол хэл судлаачидын дотор монгол хэлний залгавар бүтээвэрийг ангилах талаар ийм ноцтой зөрөө байгаа нь монгол хэлний чухал чухал асуудалыг шийдвэрлэхэд саад болж байгаагаар барахгүй, ерөнхий боловсролын сургуулиудын хэл бичигийн хичээлийн программ, сурах бичиг зохиогчидыг ихээхэн будлиаж, монгол хэлний багш нар ч сурагчидад заах төвөгтэй болж байна” (х.171) гэж уг асуудалын эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолыг тодорхойлон бичсэн байна. Юуны учир энэ асуудал ийнхүү өнөө хүртэл олон арван жил маргаантай, шийдэгдээгүй хэвээрээ байна вэ? Судлагдахуун “хоёрдмол шинжтэй байгаа” нь гол “буруу” биш бөгөөд харин судлаачид асуудалыг онол-аргазүйн зөв байр сууринаас шийдвэрлэж чадахгүй байгаатай шууд холбоотой юм.

Монгол хэлний залгавар бүтээвэрийн ерөнхий ангилалын талаархи судлаачидын саналыг хоёр үндсэн хэсэгт хувааж болно. Үүнд:

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

1. Акад. Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэлний бүтэц” (Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь) [1968] бүтээлдээ нийт залгавар бүтээвэрийг дагавар, нөхцөл гэсэн ерөнхий хоёр ангид хуваахдаа дагавар нь юм үзэгдлийн дохио, нөхцөл нь тэдгээрийн хоорондын янз бүрийн харьцааны дохио гэсэн үзэл онолыг баримтлан хэлзүйн утга илэрхийлдэг боловч ямар нэг харьцааны дохио болж үл чадах нэр үгийн олон тоо, үйл үгийн хэв, байдалын бүлэг бүтээвэрүүдийг өгүүлбэрзүйн харьцаанд орох чадамж бүхий биеэ даасан нэгж (түүнийг “үг” гэж нэрлэсэн) үүсгэх шинжийг нь гол шалгуур болгон дагаварын ангид оруулсан байна.²
2. Дээрхи бүтээл гаргахаас өмнөхи үеийн монгол хэлний хэлзүйн бичиг, хэл шинжлэлийн бүтээлүүдэд залгавар бүтээвэрийг хоёр ерөнхий ангид хуваахдаа тэдгээр нь хэлний тогтолцооны үндсэн хэсэг болох үгсийн сан, хэлзүйн байгуулал хоёрыг тодорхойлох гол хүчин зүйл гэж үзээд үгсийн сангийн буюу хэлзүйн утгын алиныг нь үүсгэж байгааг гол шалгуур болгон ангилаж байсан тул харьцааны утга илтгэдэггүй боловч хэлзүйн утга илэрхийлдэг дээрхи бүлэг бүтээвэрүүдийг нөхцөлийн ангид хамруулан үзсэн байдаг. Акад. Ш.Лувсанвандан ч түүрүү үеийнхээ бүтээлүүдэд ингэж үзэж байсан.

Энэхүү зарчимын ялгаатай хоёр бүлэг санал нь угтаа арга-зүйн хоёр өөр байр сууринаас уг асуудалыг авч үзсэнтэй холбоотой боловч дээрхи санал зөрөлдөөн нь зарим нэр томъёо, ухагдахууныг хоёрдмол утгатай, нарийн зааг ялгаагүй хутган хэрэглэсэнээс гол төлөв үүдэн гарсан мэт санагдана. Энэ нь цаанаа хэлний нэгжүүдийн түвшинг хутгасан, хоёр өөр орчины үзэгдэлийг нэг хавтгайд авч үзсэн, тогтолцооны махбодийг тодорхойлох шалгуурыг нэг утгатай, яг оновчтой хэрэглээгүй зэрэг аргазүйн шинжтэй бодит шалтгаантай байна. Иймээс энэ мэт санал зөрөлдөөнтэй асуудалын мөн чанарыг тайлбарлахын тулд монгол хэл шинжлэлийн өнөөгийн түвшинд хэрэглэж буй зарим нэр томъёог нарийвчлан ялган салгаж тодотгох, тэдгээрээр илэрэх хэл шинжлэлийн нарийн ойлголт, ухагдахууныг бие биеэс нь тодорхой зааглан нэгэн утгатай тодорхойлох шаардалгатай юм.

Акад. Ш.Лувсанванданы бүтэц хэл шинжлэлийн зарчимд тулгуурласан ангилал монгол хэлний залгавар бүтээвэрийн гол мөн чанарыг хамагийн үнэн зөв нээн гаргасан гэдэгийг монгол хэл шинжлэлд тухайн үед нь нэгэнт хүлээн зөвшөөрсөн билээ. Гэтэл түүний үзэл баримтлалын зарим ойлголт ухагдахууны утгыг өнгөц ойлгон тайлбарлах явдал судлаачидын дунд, түүний дотор уг үзэл онолыг хүлээн зөвшөөрөгчидийн дунд байсаар байгаа нь академичийн ангилалыг эрдэм шинжилгээний болон практик хэрэглээнд тууштай нэвтрүүлж, нэгэн мөр болгон дагаж мөрдөхөд саад бэрхшээл учруулсаар байна. Тухайлбал, П.Бямбасан “Бид хэлийг дохио тэмдэгийн систем гэдэгийг баримталж монгол хэлний шинжлэлд акад. Ш.Лувсанванданы анх гаргаж ирсэн морфем бол хэлний энгийн дохио учраас морфемийн нэг хэсэг нь юм үзэгдэлийн дохио, нөгөө нэг хэсэг нь тэдгээр юм үзэгдэлийн хоорондын янз бүрийн харьцааны дохио гэсэн үзэлийг монгол хэлний морфемийн үндсэн шинжийг илрүүлж, түүнд нь тохируулан ангилах хамгийн тохиромжтой шалгуур болно гэж үзэж байна. Юм үзэгдэл, тэдгээрийн хоорондын харьцааны дохио тэмдэг болох морфемийг юм үзэгдлийн дохио,

² Энэ хоёрдмол шинж чанартай бүтээвэрийн тоонд үйлт нэрийн нөхцлүүдийг бас авч үздэг. Акад. Ш.Лувсанвандан үйлт нэр үүсгэх бүлэг бүтээвэрүүдийг мөн дагаварын ангид оруулсан. Гэвч энэ нь түүний энэ үзэл баримтлалтай огт хамаагүй зүйл юм. Учир нь тэдгээрийг “цагт нэр” үүсгэх цэвэр дагавар гэж үзсэн билээ.

харьцаны дохио хоёрын аль нь болохыг ялган ангилах хуваарь үнэн бодитой ангилал болох бөгөөд хамагийн эхний ерөнхий хуваарь болно” [1977.177] гэж түүний зарчимыг бүрэн хүлээн зөвшөөрсөн боловч хэрэг дээрээ хуучин уламжлалт ангилалыг баримтлах нь зүйтэй гэж үзжээ. Ийм учраас академичийн үзэл баимтлалын зарим ойлголт, ухагдахуун, хэрэглэсэн нэр томъёоны учир утгыг сайтар ухаан ойлгох, зөв зүйтэй тайлбарлах явдал өнөө хэр чухал хэвээрээ байна.

Акад. Ш.Лувсанвандан монгол хэлний бүтэц өгүүлбэрийг бүрдүүлэгчийнхи нь талаас үг, нөхцөл гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваахдаа өгүүлбэртхи үгсийн хоорондын харьцаа заах залгавар бүтээвэрийг нөхцөл гэж үзээд хэдийгээр хэлзүйн хувьд үгийг хувилгадаг боловч өгүүлбэрт уг үгийг өөр үгтэй холбодоггүй залгавар бүтээвэрийг бусад үг бүтээх бүтээвэрийн хамт дагаварын ангид оруулан авч үзсэн билээ. Түүний үзэл онолоор, дагаварыг тодорхойлох гол шалгуур нь үгсийн сангийн шинэ нэгж үүсгэх явдал бус, харин нөхцөлөөр өөр үгтэй нөхцөлдөх чадамж бүхий үндэс үүсгэх явдал юм. Харин нөхцөлийг тодорхойлох гол шалгуур нь хэлзүйн аливаа утга илэрхийлэх явдал бус, харин өгүүлбэрзүйн ямар нэг харьцаа заах явдал юм. Тэрбээр бичихдээ: “Монгол хэлний тийн ялгалын дагавар, хамаатуулахын дагавар, үйл үгийн цаг, төлөв, нөхцөлт үйлийн дагавар нь үндэс үүсгэж чадахгүй, зөвхөн хэлзүйн хэлбэр үүсгэх үүрэгтэй ажээ. Энэ мэтээр монгол хэлний үг хувилгах дагаварын зарим нь хэлзүйн ямар нэг утгыг илэрхийлэхийн зэрэгцээгээр үгийн үндэс үүсгэх үүргийг гүйцэтгэж, нөгөө хэсэг нь зөвхөн хэлзүйн утгыг илрүүлэх төдий үүрэгтэй юм” [1964.9] гээд чухам энэ шинжийг нь баримтлан үгийн үндэс үүсгэх үг хувилгах дагаваруудыг нөхцөлийн ангид оруулаагүй билээ.

Энэ тухайгаа акад. Ш.Лувсанвандан тодорхой дурдсан байна. Тэрбээр ийм бүлэг бүтээврүүдэд нэрийн олон тоо, үйл үгийн хэв, байдалын хэмээгдэх бүтээврүүд орж болохыг дурдаад тэдгээрийн тухай нэгбүрчлэн тодорхойлон бичихдээ: “Монгол хэлний нэрийн олны дагавар нь үгэлбэрийн доторхи үгсийн харьцааг заадаггүй, анхдагч буюу үүсмэл үндэс үүсгэдэг тул нөхцлийн ангид багтахгүй харин үг бүтээх дагаврын ангид багтаах ёстой гэж үзэв. ...Монгол хэлний үйл үгийн хэвийн дагавар гэгч нь тусах үйл үгээс эс тусах үйл үг, мөн эс тусах үйл үгээс тусах үйл үг, бас тусах үйл үгээс дам тусах үйл үг, эс тусах үйл үгээс дам эс тусах үйл үгийн үндэс үүсгэх дагавар болох учир бид энд үгэлбэрийн доторхи үгсийн харьцааг заах нөхцөл биш, харин үйл үгээс дам үйл үг үүсгэх дагаврын зүйлд багтах ёстой гэж үзлээ. ...Үүнчлэн монгол хэлний үйл үгийн байдлын дагавар гэгч нь бас л янз бүрийн утгатай үйл үгийн үндэс үүсгэх дагавар юм. Энэ байдлын дагавар гэгчийн зарим нь үйл үгийн үндсэнд биш, харин нөхцөл авдаггүй янз бүрийн дүрслэх үгэнд залгаж янз бүрийн утгатай үйл үгийн үндэс үүсгэдэг” [Лувсанвандан,1967.43-44] гэжээ. Мөн тэрбээр үзэл баримтлалаа товч томъёолон: “Залгавар морфемийг дотор нь үг бүтээх дагавар, үг холбох нөхцөл гэж ангилаж болно. Үг бүтээх дагавар нь язгуур морфемд хурсан дотоод харьцааг зааж, үг холбох нөхцөл нь нэг үг нөгөө үгтэйгээ хэрхэн харьцах гадаад харьцааг заана” [Лувсанвандан, 1979.7] гэж бичсэн нь монгол хэлний залгавар бүтээвэрийн хоёр үндсэн бүлэгийг тодорхойлсон хамагийн зөв зүйтэй үндэслэл юм.

Харин бид зөвхөн “Лувсанванданы үг”, “Лувсанванданы нөхцөл”, “Лувсанванданы дагавар” гэсэн ойлголтуудыг тэдгээрийн жинхэнэ мөн чанараар нь ойлгож, монгол хэлний хэлзүйн ном зохиолд хэвшин тогтсон “үг”, “нөхцөл”, “дагавар” хэмээх уламжлалт ойлголтуудаас зарчимын ялгаатай, өөр түвшини ойлголтууд болохыг тун бүтээлчээр хүлээн авах хэрэгтэй юм. Энэ зорилгын үүднээс бид

“харьцал”, “үүсгэвэр” зэрэг нэр томъёог зохион хэрэглэсэн бөгөөд “үндэс” хэмээх нэр томъёог шинэлэг утгаар тайлбарлаж буй билээ. Ингэсэнээрээ, акад. Ш.Лувсанвандан дээрхи бүлэг бүтээвэрүүдийг “нөхцөл” биш “дагавар” гэж мөн чанарыг нь зөв тодорхойлосон боловч шинэ ухагдахуунд тохирсон шинэлэг нэр томъёо хэрэглээгүйн улмаас “зөв ярьж буруу ойлгогдох” зөрчилийг арилгахад нэмэр болох юм. Эцэс төгсгөлгүй энэ маргааныг дуусгахад эдгээр бүтээвэр нь “харьцал бүтээвэр” биш “үүсгэвэр бүтээвэр” юм гэж ойлгох нь чухал юм.

Аливаа олонлигийн нэгэн адил монгол хэлний залгавар бүтээвэрийг янз бүрийн зорилгоор, өөр өөр шалгуураар ангилж болох нь мэдээж. Хэлийг жинхэнэ тогтолцоот бүтэц бүхий цогц болохынхи нь хувьд авч үзэхэд залгавар бүтээвэрүүдийг бүтэц-үүрэгийн талаас нь ангилах нь хамагийн чухал бөгөөд акад. Ш.Лувсанвандан чухамхүү ийм ангилал санал болгосон юм. Нөгөө талаас, хэлний үгзүйн бүтэцийг товчоолон бичихэд залгавар бүтээвэрийн ангилалыг үгсийн сан-хэлзүйн талаас нь авч үзэх шаардалга гарч болох бөгөөд энэ үед “дагавар-нөхцөл” гэсэн ангилал хэрэг болох юм.

Монгол хэлний хэлзүйн ном зохиолд авч үздэг үгсийн сан-хэлзүйн ангилал нь дотороо бас ихээхэн санал зөрөлдөөнтэй байдаг. Тухайлбал, залгавар бүтээвэр “-цгаа”-г дээрхи завсарын гэж үздэг 3 бүлэг бүтээвэрт гурвууланд нь оруулж үзсэн байдаг. Зарим нь хэвийн нөхцөл [Бобровников, 1849.128; Котвич, 1902.99; Лувсанвандан-Дэмчигдорж, 1951.96; Лувсанвандан, 1961.137], нөгөө хэсэг нь байдалын нөхцөл [Алексеев, 1965.66,71; Цыдыпов, 1972.169], гуравтхи нь олон тооны нөхцөл [Владимирцов, 1929.233-134; Козин, 1946.135; Котвич, 1962.207; Тодаева, 1951.99] гэж үзсэн байна. Хэвийн нөхцөлд оруулдаг “-лц”, “-лд”, мөн дээр дурдсан “-цгаа” залгавар бүтээвэрүүд нь үйл хөдлөл хэлзүйн эзэн биед чиглэсэн утга буюу хэвийн утга илэрхийлнэ гээд тэдгээрийг хэвийн нөхцөл гэж үзэх хэрэгтэй гэсэн санал ч байдаг [Шевернина, 1985А.143].

Н.А.Баскаков [1963;1975] тюрк хэлний залгавар морфемийг олон шинж чанараар нь тодорхойлоод үгийн сан, хэлзүйн аль алинд хамаарагдах завсарын олон үзэгдэлийг тусган арав ангилсан байдаг. Үүний жишигээр тюрк, монгол мэтийн залгамал хэлнүүдийн залгавар морфем нь дотороо олон янзын шинж чанартай, тэр шинж чанарыг нь харгалзаж хэд хэдэн бүлэгт хуваан үзэх шаардалга байна гэж үзээд П.Бямбасан монгол хэлний залгавар бүтээвэрийг:

1. Үг үүсгэх дагавар (х.172-173)
2. Хэвийн нөхцөл (х.173-174)
3. Байдалын нөхцөл (х.174)
4. Гийн ялгалын нөхцөл (х.174-175)
5. Төгсгөх нөхцөл (х.175)

гэж хуваагаад төгсгөх нөхцөлд нэрийн хамаатуулах, үйл үгийн төлөв, нөхцөлт үйл, үйлт нэрийн нөхцөлүүдийг оруулсан байна [Бямбасан, 1977].

Мөн Н.А.Баскаковын хэв, байдалын дагавар үг бүтээх, үг хувилгах шинжийн аль алиныг хадгалсан гэж үздэг тухай дурдаад доктор Д.Отгонсүрэн бичихдээ: “Гэвч хэлний бодит байдалд залгавар морфем бүхэн нэг бол үг бүтээнэ, үгүй бол үг хувилгана гэж үзэхэд бэрхшээлтэй бөгөөд үг бүтээх, үг хувилгах морфемийн аль алиных нь шинжийг нэгэн зэрэг хадгалсан морфем байгааг огт үгүйсгэж болохгүй бизээ. Монгол хэлний хэв, байдалын утга илтгэдэг залгаваруудыг үг бүтээдэг, үг хувилгадаг морфемийн алинд нь оруулах тухай санал нэг мөр болоогүй байгаа нь уг морфем хоёрдмол шинжтэй гэдэгийн баримт ч байж болох юм. Бидний бодолоор, байдалын

утга илтгэдэг залгаваруудын үг хувилгах шинж нь тодорхой, хэвийн утга илтгэдэг залгаварууд үг бүтээх шинжээрээ байдалаас давуу, тодруулбал, үг бүтээх, үг хувилгах хоёрдмол шинжтэй юм” [1978.20-21] гэжээ.

Энэ талаар Ц.Өнөрбаян бичихдээ: “Ингэж үзвэл, язгуурын зарим шинж дагаварт, дагаварын зарим шинж нөхцөлд байхаас гадна нөхцөлийн зарим шинж дагаварт, дагаварын зарим шинж язгуурт байх жишээтэй юм. Тэгвэл язгуур, дагавар, нөхцөл гэж ангилчихаад хооронд нь нэвтэршгүй зааг тогтоож болохгүй. Ийнхүү ажиглан үзвэл хэвийн бүтээврүүдэд дагаварынх нь шинж голлож, нөхцөлийнх нь шинж нь дагалдаж, олон тоо, байдлын бүтээврүүдэд нөхцлийнх нь шинж голлож, дагаварынх нь шинж дагалдаж байгаа тул хэвийн бүтээврийг дагаврын ангид, олон тоо, байдлын бүтээврийг нөхцлийн ангид багтааж үзэх саналтай байна” [1994.84] гэжээ.

Г.Д.Санжеев, араас нь үг бүтээх дагавар залгаж болох эсэхээр нь шалгуур хийж хэвийн нөхцөлүүдийг дагаварын ангид, байдалын нөхцөлөөс “-ч, -чих, -схий, -зана⁴, -цгаа⁴”-гаас бусадыг дагаварын ангид оруулжээ [1960.288-296]. Гэвч хэвийг хэлзүйн категори гэж үзсэн нь [Санжеев, 1963.12-71] үүнтэй харшлахгүй юм. Судлаач П.Бямбасан эдгээр бүлэг бүтээврийн хэлзүйн мөн чанарыг нээн гаргах талаар олон тооны өгүүлэл, ном бичсэн. Тэрбээр монгол хэлний хэв, байдалын айн талаар дорвитой бүтээл [1970] туурвиж, нэр үгийн тооны айн талаар тусгайлан судалжээ [1975]. Тэрбээр бичихдээ: “Монгол хэлний үйл үгийн хэвийн нөхцлүүд язгуурын дараа тохиолдож юм үзэгдлийн дохио болж үг бүтээхгүй, харин үйл, үйлийн эзний харьцаа буюу үгсийн хоорондын харьцааг заана. Иймд тэдгээрийг нөхцөл гэж үзэх хэрэгтэй” [1977.174], “Залгавар нь үг бүтээж үйл хөдлөлийн дохио болох эсэх, язгуурын дараа шууд тохиолдож болох эсэх зэрэг агуулга, үүрэг, байр, хугацаагаараа ялгарна, Энэ ялгаан дээр нь үндэслэж залгавар морфемийг дагавар, нөхцөл гэж хоёр хуваадаг, Энэ хуваариар хэв, байдал (-ч, -чих, -схий, -цгаа⁴, -зана⁴) цаг заах, захирах хүсэх, нөхцөл үйл, үйлт нэрийн нөхцөл гэж голдуу нэрлэсээр ирсэн морфемуудыг нөхцөлийн ангид, бусадыг нь дагаварын ангид багтааж болох юм” [1982.77] гэжээ. Мөн тэрбээр нэр үгийн ганц, олон тооны ай монгол хэлэнд байна гэж үзээд “-чууд²”, “-с”, “-д” бүтээврүүдийг үг үүсгэх дагавар, “-нууд²” бол бие даасан морфем биш, тогтворгүй “-н”-тэй үндэс гэж үзээд “нар(нэр)”, “-ууд²” –ыг хэлзүйн ай илэрхийлэх нөхцөлүүд гээд монгол хэлний ганц, олон тооны ай нь ерөнхий ба тодорхой, ганц ба олоны эсрэгцэл дээр үндэслэсэн гэж үзжээ. Монгол хэлэнд тооны ай байхгүй гэж Б.Ринчен [1964], Чой.Лувсанжав [1977] нар үзсэн ба Ш.Лувсанвандан [1968] олон тооны бүтээврүүдийг дагавар гэж үзжээ.

НОМ ЗҮЙ

- Алексеев, 1965 - Д.А.Алексеев, К происхождению глаголо-образующих суффиксов в монгольских языках - Филология и история стран зарубежной Азии и Африки, Л., 1965, с. 3-4
- Баскаков, 1963 - Н.А.Баскаков, Структура слова в тюркских языках - Морфологическая структура слова в языках различных типов, М-Л., 1963
- Бобровников, 1849 - А.Бобровников, Грамматика монгольско-кальмыцкого языка, Казань, 1849, 400 с.

- Бямбасан, 1970 - П.Бямбасан, ОЦМХ-ний үйл үгийн хэв, байдал, ХЗС, б. ҮШ, УБ., 1970, х. 201-301
- Бямбасан, 1975 - П.Бямбасан, ОЦМХ-ний үгийн бүтэц, нэр үгсийн аймаг, УБ., 1975, 155 х.
- Бямбасан, 1977 - П.Бямбасан, Монгол хэлний залгавар морфемийн ангиллын асуудалд - МС, б. Ү(13), 1977, х. 168-179
- Бямбасан, 1982 - П.Бямбасан, Орчин цагийн монгол хэлний үйл үгийн систем - ХЗС, б. ХҮ, 1982, х. 73-84
- Владимирцов, 1929 - Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Введение и фонетика, Л., 1929, 433 с.
- Котвич, 1902 - Вл. Котвич, Лекции по грамматике монгольского языка, СПб., 1902, 203 с.
- Котвич, 1962 - Вл.Котвич, Исследование по алтайским языкам, М., 1962, 371 с.
- Лувсанвандан, 1951 - Ш.Лувсанвандан, Б.Дэмчигдорж, Монгол хэлний зүй, 1-р дэвтэр, Авиа ба үгийн зүй, УБ., 1951, 166 х.
- Лувсанвандан, 1961 - Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэл, Бээжин, 1961
- Лувсанвандан, 1964 - Ш.Лувсанвандан, Монгол хэлний үгийн бүтцийн тухай асуудалд - МУИС ЭШБ, б. ҮП, 1964, х. 3-15
- Лувсанвандан, 1967 - Ш.Лувсанвандан, Монгол хэлний үгсийг аймаглах тухай асуудалд - ХЗС, б. V, 1967, х. 15-49
- Лувсанвандан, 1968 - Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь, ШУАХ, УБ., 1968, 192 х.
- Лувсанвандан, 1979 - Ш.Лувсанвандан, Монгол хэлний бүтцийн тухай асуудалд - ХЗС, б. XIII, 1979, х. 5-14
- Лувсанжав, 1977 - Чой.Лувсанжав, Туслах үйл үгийн тухай - ОУМЭ-ний III их хурал, б. II, 1977, х. 99-101
- Отгонсүрэн, 1978 - Д.Отгонсүрэн, Монгол хэлний үгийн сан-хэлний зүйн утга илэрхийлдэг зарим морфем - ШУАМ, 1978, '2, х. 20-26
- Өнөрбаян, 1994 - Ц.Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үгзүй, УБ., 1994, 238 х.
- Санжеев, 1960 - Г.Д.Санжеев, Современный монгольский язык, М., 1960
- Санжеев, 1963 - Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, Глагол, М., 1963, 266 с.
- Тодаева, 1951 - Б.Х.Тодаева, Грамматика современного монгольского языка, Фонетика и морфология, М., 1951
- Цыдыпов, 1972 - Ц.Ж.Цыдыпов, Аналитические конструкции в бурятском языке, Улан-Удэ, 1972
- Шевернина, 1985А - З.В.Шевернина, Глагольный суффикс -цаа в современном монгольском языке - Монгольский лингвистический сборник, 1985, х. 140-145

РЕЗЮМЕ

В статье затрагивается бытующая в монгольском языкознании дискуссия относительно того, к какой категории – словообразовательной или словоизменительной – отнести определенные группы аффиксов: множественного числа у имени, залоговые и видовые у глагола.

Существует в основном две группы мнений по этому поводу:

- 1) Акад. Ш.Лувсанвандан³ разделяя аффиксальные морфемы на суффиксы (знаки предметности) и флексии (знаки отношений между ними) включил эти группы морфем в класс суффиксов, хотя имеют грамматическое значение, а образуют реляционную основу, способную вступать в синтаксические связи. Зародыши этой концепции посеяны в грамматике А.Бобровникова.
- 2) В большинстве работ по монгольской грамматике, даже после появления труда Ш.Лувсанвандана общее разделение аффиксальных морфем производится по тому, какое значение в языковом строе – лексическое или грамматическое (в узком смысле) они образуют. По такому критерию рассматриваемые группы аффиксов, естественно, относятся к флексиям. Приверженцем этой концепции является, например, П.Бямбасан⁴. В своих ранних работах Ш.Лувсанвандан поступал по этому же принципу. Понятно, что такое принципиальное разногласие во мнениях обусловлено в глубине своей, прежде всего, методологически разными позициями. Однако, как считает автор, разногласие углубляется тем, что в постановке вопроса некоторые термины и понятия употреблены альтернативно. За этим стоят конкретные методологические неточности, как смешивание уровней языковых единиц, размещение на одной плоскости несопоставляемых понятий, неоднозначность критериев и т.п.

Касаясь этой проблемы Ц.Өнөрбаян⁵ пишет, что суть дискуссии определяется во-первых, двоякостью этих аффиксов в значении, функции и дистрибуции; во-вторых, крайностью исследователей в их рассмотрении. Сходя во мнениях о двоякости этих аффиксов, автор считает, что это двоякость проявляется в их переходности. Они суффиксальны синтаксически и флексивны морфологически. Этот вывод вытекает из того положения, где автор объяснил природу реляционных формантов.

Таким образом, рассматриваемые группы аффиксов являются основообразующими по отношению к реляционным формантам и словоизменительными по отношению к словообразовательным.

³ Ш.Лувсанвандан, Орчин цагийн монгол хэлний бүтэц (үг, нөхцөл хоёр нь), УБ., 1968

⁴ П.Бямбасан, “Монгол хэлний залгавар морфемийн ангиллын асуудал” –МС V (13), 1977, с. 168-

⁵ Ц.Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үг зүй, УБ, 1994. 84